

Удиртгал: Угсаатан, судалгааны арга зүй хийгээд мал аж ахуй

Г.Мөнх-Эрдэнэ

МУИС/Оксфордын их сургууль

munkherdene.g@num.edu.mn

Монголын Антропологийн Тойм (Mongolian Anthropological Review) сэтгүүлийн энэ дугаарт угсаатны асуудал, судалгааны арга зүй, мал аж ахуй хийгээд хүний нөөцийн асуудлыг хөндсөн сонирхолтой өгүүллүүд хэвлэгдлээ. Антропологичид 1970-аад оноос **угсаатан** гэх ойлголтыг идэвхтэй хэрэглэх болсон нь 19-р зууны колоничлолын бүтээсэн арьстан зэрэг сөрөг утгатай ойлголтоос салах гэсэн хандлага байлаа (Мөнх-Эрдэнэ, Чулуунбат 2017). Гэвч өнөөдөр антропологийн ухаанд угсаатан, угсаатны ялгаа гэх ойлголтын хэрэглэх, судлах нь харьцангуй багасаж, илүү соёлын ялгаа, нийгмийн ялгаа, нутаг орны ялгаа гэх зүйлсийг хэлэлцэх болжээ.

Тухайн үеийн Монгол Улсад ч Зөвлөлтийн нөлөөтэй хөгжиж байсан Угсаатны зүй гэх ухааны судалгаа ч дээрх чиглэлд хөгжиж, монголчуудыг олон ясны болгон хувиргасан түүхийг судлаач П.Мягмар өөрийн өгүүллээрээ тодруулан гаргажээ. Энэ уламжлал өнөө ч бөх бат байгаа төдийгүй одоо антропологийн ухаанд харьцангуй хэрэглэгдэхээ байсан “байгаллаг, биологийн” угсаатан гэх ойлголтыг заримдаа хэтэрхий чухалчлан жишээ нь, Монгол Улсад олон угсаатан (Зөвлөлтийн үед ястан) амьдран суудаг мэт дүр зургаа бүтээсээр л байгаа ажээ. Монголын нийгмийн ухааны гол гол унших бүтээл, судалгаа өнөө ч гэсэн онцын өөрчлөлт шинэчлэлгүй, өмнөх зүйлсээ их бага хэмжээнд давтсаар байгааг энэ жишээ тодхон харуулж байна.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт антропологийн **судалгааны арга зүйтэй** холбоотой хоёр өгүүлэл хэвлэгдсэн нь ойрын хэдэн жил монголд тохиогоогүй үйл явдал боллоо. Тэртээ 1958 онд С.Бадамхатан “Этнографийн судалгаа хийх арга барилын тухай” өгүүллээ нийтлүүлсэн нь энэ төрлийн судалгааны арга зүйн тухайн анхны эрдэм шинжилгээний ажил болсон юм. Тэр цагаас хойш антропологийн судалгааны арга зүйн тоймтой, дориун судалгаа хэвлэгдээгүй байгаа нь тус салбарын бодит байдал билээ. Судлаач Ц.Мөнхзаяа Шашны итгэл үнэмшлийн асуудлыг илүү тодруулан гаргаж ирэхэд тоглоом туршилтын арга нь нэмэлт эх сурвалж бэлтгэх, мэдээллийг баталгаажуулахад үр дүнтэй байгаа судалгааны дүгнэлт гарчээ. Харин судлаач Б.Цэвэлмаа богино хугацааны хээрийн судалгааны үед тоон болоод чанарын судалгааны аргын хослуулан ашиглаж, мэдээллийн цуглуулалт, чанар-баталгаат байдал, судалгааны үр дүнг сайжруулах боломжийн тухай судалгаандаа дурдсан байна.

Мал аж ахуйтай холбоотой хоёр өгүүллийн нэгт, судлаач Б.Балжинням монголын нийгмийн нэгэн сонирхолтой үзэгдэл болох малын хулгайн түүхийг аман түүх, оролцон ажиглах арга зүйгээр мөшгөн үзжээ. Хатуу чанга хараа хяналттай гэгддэг социализмын үед ч мал нуун дарагдуулах, мал хулгайлан үйлдэл цөөнгүй байсан бөгөөд ёстой л нэгэн малчны хэлсэн шиг “мал байгаа л бол малын хулгай байна” гэдгийг сануулах мэт. Социализмын үеийн сайн эрийг “домоглон шүтэх” хандлага энэ бүхэнд нөлөөлдөг байсныг үгүйсгэхгүй ч монголын соёлтой уялдаатай энэ үзэгдэл нь тэр бүр эвгүй, муу хэлэгдээд байдаггүй онцлогтойг энэ өгүүлээс харж болох нь. Хоёрдугаар өгүүлэлд судлаач Бүрэнжаргал, Цэгээн нар эрчимжүүлсэн мал аж ахуй тэр дундаа үхрийн аж ахуйн нь зохион бодлого, санхүүгийн дэмжлэгтэй бол нүүрстөрөгчийн ялгаруулалтаа бууруулах боломжтой гэж мэтгэж байна. Зарим талаар Монгол Улсад мал аж ахуйгаа эрчимжүүлэх тухай ярьдаг ч өнөөх зорьж буй аж ахуйн хэлбэр нь нүүрстөрөгчийн ялгаруулалт гэх мэт асуудал бэрхшээлтэй байдаг тухай тэр бүр дурддаггүй. Энэ нөхцөлд тэдний хийсэн судалгаа баримжаа авах нэгэн сэжүүр болохыг үгүйсгэхгүй.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт **хүний нөөцийн асуудалтай** холбоотой нэг өгүүлэл хэвлэгдлээ. Монгол дахь антропологийн ухаанаар суралцсан эхэн үеийн төгсөгчид хүний нөөцийн салбарт ажлын гараагаа эхэлсэн нь санамсаргүй хэрэг биш юм. Тухайн үед хүний нөөцөөр мэргэжилтэн бэлтгэдэг сургууль, сургалтын төв байгаагүй учир антропологи зэрэг “хүнтэй ажилладаг” мэргэжлийн төгсөгчдөөс энэ салбарт ажиллах боломжийг нээж байлаа. Өнөө энэ салбар тэлж хөгжин, бие даасан мэргэжилтэн бэлтгэдэг бүхэл бүлэг болсон ч хүний нөөцийн хяналт, аудит хийх асуудалд тодорхой санал гаргаж буйгаа судлаач өөрийн өгүүллээр илэрхийлсэнг уншигч та үзэх боломжтой боллоо.

Ийнхүү тус сэтгүүлийн ээлжит нэгэн дугаар олон сэдвийг хамарсан сонирхолтой судалгаа нийтлүүлж байна. Судалгаагаа хэвлүүлэхийг хүссэн судлаач, шүүмжлэгч хэн бүхэн сэтгүүлийн сайт рүү уг холбоосоор <https://journal.num.edu.mn/MAR> нэвтрэн орж, шаардлага, журам зэрэгтэй танилцах боломжтой.

Ном зүй

Бадамхатан, С., 1958. *Этнографийн судалгаа хийх арга барилын тухай*.

Улаанбаатар: Шинжлэх Ухаан, Дээд Боловсролын Хүрээлэнгийн хэвлэл.

Мөнх-Эрдэнэ, Г. болон Чулуунбат, П., 2017. *Нийгэм-соёлын хүн судлалын удиртгал*. Улаанбаатар: МУИС Пресс.

Editorial Introduction: Ethnicity, Research Methods and Pastoralism

Gantulga Munkherdene

Department of Archaeology, Anthropology and Demography and the Centre for Development Studies, National University of Mongolia

School of Geography and the Environment, University of Oxford

munkherdene.g@num.edu.mn

In this issue of *Mongolian Anthropological Review*, a number of engaging articles addressing ethnicity, research methodology, pastoralism, and human resource issues have been published. Anthropologists began actively using the concept of “**ethnicity**” from the 1970s onward as part of an attempt to move away from negatively charged concepts such as “race,” which had been shaped by nineteenth-century colonialism (Munkh-Erdene and Chuluunbat 2017). However, in contemporary anthropology, the use and study of ethnicity and ethnic difference have relatively declined, with greater attention now being paid to cultural, social, and regional differences.

In Mongolia as well, ethnography, which developed under Soviet influence, followed a similar direction. In his article, P. Myagmar examines the historical process through which Mongolians came to be divided into numerous “*yastan*” or subgroups. This tradition remains deeply entrenched today, and concepts of “natural” or “biological” ethnicity ideas that are now relatively outdated within anthropology are still sometimes overemphasized. For example, representations continue to be produced suggesting that Mongolia is home to many distinct ethnic groups (referred to during the socialist era as *yastan*). This clearly demonstrates how major readings and studies in Mongolian social sciences have undergone little substantial revision or transformation, often continuing to reproduce earlier ideas to varying degrees.

This issue also includes two articles on anthropological research methodology, something rarely seen in Mongolia in recent years. As early as 1958, S. Badamkhatan published his article “On the Methods of Conducting Ethnographic Research,” which became the first scholarly work on this type of research methodology. Since then, however, few comprehensive and substantial studies on anthropological methodology have been published, reflecting the current state of the discipline. Ts. Mönkhzaya concludes that game-based experimental methods can effectively generate supplementary sources and help verify information when examining issues of religious belief. Meanwhile, B. Tsevelmaa discusses how combining quantitative and qualitative research methods during short-term fieldwork can improve data collection, reliability, and overall research outcomes.

Two articles in this issue focus on pastoralism. In the first, B. Baljinyam investigates the history of livestock theft in Mongolia, a fascinating social phenomenon through oral history and participant observation methods. Even during socialism, often remembered as a period of strict surveillance and control, cases of concealing and stealing livestock were not uncommon, reminding us of the saying of one herder: “As long as there is livestock, there will be livestock theft.” Although the romanticization of “sain ers” from the socialist era may have influenced perceptions of such practices, the article also shows that livestock theft, being intertwined with Mongolian culture, has not always been viewed entirely negatively. In the second article, Bürenjargal and Tsegeen argue that intensified livestock production particularly cattle farming could reduce carbon emissions if supported through appropriate organization, policy, and financial assistance. While there is much discussion in Mongolia about intensifying livestock production, there is comparatively little mention of the problems associated with such systems, including carbon emissions. In this context, their research may provide a useful point of reference for future discussions.

This issue also includes an article related to human resources. It is no coincidence that some of the earliest graduates trained in anthropology in Mongolia began their careers in the human resources sector. At the time, there were no schools or training centers specifically preparing HR professionals, which opened opportunities for graduates from disciplines such as anthropology that emphasized working with people. Although the field has since expanded and developed into an independent profession with its own specialized training programs, the author’s article offers important proposals regarding human resource monitoring and auditing. Readers now have the opportunity to engage with these ideas.

Thus, this latest issue of the journal presents engaging research covering a wide range of topics. Researchers and reviewers interested in publishing their work may visit the journal’s website through the following link, <https://journal.num.edu.mn/MAR> where they can find the submission requirements, guidelines, and other relevant information.

Reference

- Бадамхатан, С., 1958. *Этнографийн судалгаа хийх арга барилын тухай*. Улаанбаатар: Шинжлэх Ухаан, Дээд Боловсролын Хүрээлэнгийн хэвлэл.
- Мөнх-Эрдэнэ, Г. болон Чулуунбат, П., 2017. *Нийгэм-соёлын хүн судлалын удиртгал*. Улаанбаатар: МУИС Пресс.